

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 09-ний ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-06-09

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтон бичиж, **2025 оны 06 дугаар сарын 17-ны “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.
- 8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
- 8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
- 8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
- 8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	“Хотын иргэдийн баяр-Хүрээ даншиг” наадмын нэгдсэн арга хэмжээний бэлтгэл, иргэд олон, нийтийн аюулгүй байдал, орчны ногоон байгууламж, тохижилтын ажил зэргийг сайтар хангах.	НХХ, Соёлын ордон, Биеийн тамир, спортын хороо, чиг үүргийн байгууллагууд
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, инженер хангамжийн байгууллагууд бэлтгэл бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, дүнг танилцуулах.	ХХҮХ, Инженерийн дэд бүтцийн байгууллагууд
3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг амарч байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажлыг хугацаанд нь эхлүүлж, дуусгах.	Боловсролын хэлтэс, ЕБС, СӨББ-ууд
4	Дүүргийн хэмжээнд 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, танилцуулах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, нийт байгууллага
5	Үерийн хамгаалалтын далан суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	Дүүргийн авто зам, инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гаднах орчны аюулгүй байдлыг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Ажлын хэсэг
7	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх, тохижуулах ажлуудыг эрчимжүүлэх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
8	Нийслэлийн хэмжээнд тоос, тоосонцроос урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, автозам, явган хүний зам талбайг усалж, чийгшүүлэх ажлыг сайтар зохион байгуулах.	
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9	2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр дуусах ОНХС-гийн санал асуулгад ажилтан, албан хаагчид, иргэдийг идэвхтэй хамруулах, байгууллагын чиг үүргийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, чухал хэрэгцээт ажлуудад иргэдийн саналыг түлхүү өгүүлэхэд анхаарах;	СТСХ, Хороод Нийт байгууллага
10	Он дамжин хэрэгжиж буй болон энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаа эрчимжүүлэх; Үүнд: - ЖДҮҮДТ -Логоны машины ашиглалт, - Илч-Орд ОНӨААТҮГ -Явган замын хавтан үйлдвэрлэх төхөөрөмж, - Багахангай тохижилт ОНӨААТҮГ -2024, 2025 онуудын нөхөн сэргээлтийн ажил, Зөөврийн ариун цэврийн байгууламж, Үерийн далан, суваг шуудууны арчлалт хамгаалалтыг сайжруулж, аюулгүй байдлыг хангуулах, - Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ -Зүлэгт болон элстэй талбай, усан	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ОНӨААТҮГ-ууд

	оргилуурыг байнгын ашиглалтад оруулах, ногоон байгууламжийн хашаа, усны савнуудыг будах, - Ус суваг ашиглалтын товчоо-Чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа нийтийн эзэмшлийн талбай, бусдад хохирол учруулахгүй байхад анхаарах;	
11	Үндэсний их баяр наадмын өдрүүдэд дүүрэгт зохион байгуулагдах арга хэмжээний үеэр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд гэрээ байгуулсан хот, дүүргээс зочид, төлөөлөгчид хүрэлцэн ирэх, урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулах тул зохион байгуулалт, бэлтгэл ажилд анхаарах;	ТЗУХ, Нийт байгууллага
12	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг байгуулах тухай захирамжуудын хэрэгжилтэд үнэлгээ хийж, үйл ажиллагааг эрчимжүүлэх;	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТЗУХ
13	Дүүрэгт зохион байгуулагдах “Нарны тойром” шагайн харвааны тэмцээний бэлтгэлийг сайтар ханган, тамирчид, иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулах;	НХХ, БТСХ, Ажлын хэсэг, Нийт байгууллагууд
14	Дүүрэгт нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсэнтэй холбогдуулан иргэдийн зорчих маршрут болон цагийн хуяаарьт өөрчлөлт оруулах тухай саналыг холбогдох газарт хүргүүлэх;	ТХҮХ
15	Нөхөн сэргээлт хийгдсэн байршилд хог хаягдал ил задгай асгаж, буулгаж буй иргэдэд арга хэмжээ авах тухай захирамжийн төсөл бэлтгэх;	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ТЗУХ
16	Хөрөнгө оруулалтын ажлуудад явцын хяналт тавих ажлын хэсгүүдийг яаралтай байгуулах;	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, СТСХ, ТХҮХ
17	Улаанбаатар-Чойр чиглэлийн олон улсын чанартай А0101 авто замын дагуу болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах;	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
18	ААНБ-уудын удирдах албан тушаалтнууд байгууллагынхаа орчны 50м талбайн орчны аюулгүй байдал, цэвэрлэгээг тогтмолжуулах;	Нийт байгууллагууд
19	Нийслэл, дүүргийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлуудаа олон, нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд
20	Дүүргийн нутаг дэвсгэр дэх “Тахилгат овоо”-нуудыг тахиx арга хэмжээг зохион байгуулах бэлтгэлийг ханган, ажилтан, албан хаагчид, иргэдийг өргөнөөр оролцуулах;	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Холбогдох байгууллагууд
21	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сул ажлын байранд шинээр томилогдон ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах, байгууллагын соёлыг таниулахад анхаарч ажиллах;	Нийт байгууллагууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР